



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 4/08

Мөрөн сум

**Хяналтын камер ашиглах журам
батлах тухай**

Монгол Улсын боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.8, Байгууллагын нууцын тухай хуулийн 3.1.2, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8.1, 8.2 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтнуудын ажлын цаг ашиглалтанд хяналт тавих, аливаа төрлийн зөрчил дутагдалаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, ажлын байрны эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагаар ажлын байранд хяналтын тоног төхөөрөмж ажиллуулах, ашиглах журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Хяналтын тоног төхөөрөмжийн өдөр тутмын ашиглалт, үйлчилгээ, найдвартай хэвийн ажиллагааг хариуцахыг Мэдээлэл зүйн багш (Б. Төртогтох), тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн ажилтан (Э. Лхамсүрэн)-д нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



М. АРИУНАА